



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Г Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолын 7
хавсралтад нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банкны тухай хуулийн 6.2.7 дах заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-д дор дурьсан агуулгатай 1.2.9, 1.3.5, 1.7 дахь заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ “1.2.9 Банкны тухай хуулийн 6.2.7-д заасан “харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ”,

2/ “1.3.5 Андеррайтерийн үйл ажиллагааг харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээтэй”,

3/ “1.7 Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээг эрхлэх этгээд нь энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлага нөхцлийг хангасан байна.”.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН